



Г

“МИГ ДААТГАЛ” ХХК-Д

Г

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: [info@frc.mn](mailto:info@frc.mn), <http://www.frc.mn>

2022.06.02 № ЦМ-22/44 .

танай 2011.05.17 -ны № 01/11-556 -т

Г

Даатгалын бүтээгдэхүүн  
бүртгэсэн тухай

Г

“Миг даатгал” ХХК-ийн 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 01/11-556 тоот хүсэлтэд үндэслэн зээлийн даатгалын хэлбэрт хамаарах “Худалдааны зээлийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг бүртгэв.

## Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2022	Сар	05	Өдөр	17	
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Миг даатгал ХХК						
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	“Худалдааны зээлийн даатгал”						
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Зээлийн даатгал						
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр			Огноо		Дугаар	
		Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол			2022.05.17		А/22-92	
6	Цахимаар борлуулах эсэх	<input type="checkbox"/> Гийм <input checked="" type="checkbox"/> гүй						
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог			Нэр			
		Чулуунбаатар			Баттүшиг			
<b>Мэдээллийн төрлийг сонгоно уу.</b>								
8	<input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх							
<b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b>								
9	Даатгалын зүйл	Худалдан авагч даатгуулагчид төлөх ёстой авлагуудаа даатгалын тохиолдол учирсны улмаас төлж чадаагүй шалтгаанаар даатгуулагчийн бизнесийн үйл ажиллагаанаас хохирол хүлээх эрсдэлтэй холбогдох түүний санхүүгийн ашиг сонирхол байна.						
	Даатгалын үндсэн эрсдэл	1. Даатгалын гэрээнд заасан хүлээлгийн хугацаа дуусахад даатгагдсан авлагууд бүрэн эсхүл аль нэг хэсэг нь төлөгдөөгүй хэвээр үлдэх; 2. Шүүхээс худалдан авагчийг төлбөрийн чадваргүй гэж зарлах тухай хууль зүйн хувьд хүчин төгөлдөр тодорхойлолт/шийдвэр гаргаж тухайн худалдан авагчид дампууруулах процедуруудаас хэрэглэх (Монгол Улсын холбогдох хүчин төгөлдөр хууль тогтоомжийн дагуу) өдрийн байдлаар даатгагдсан авлага нь бүрэн эсхүл хэсэгчлэн төлөгдөөгүй үлдсэн байх; 3. Дараах нөхцөл болзол хангагдсан нөхцөлд даатгуулагч нь төлбөр амжилттай төлөгдсөн эсэхээс үл хамааран даатгагдсан хугацаа хэтэрсэн авлагуудыг худалдан авагчаар төлүүлэхтэй холбоотой зардал гаргах. Үүнд: 3.1. Дээрх зардлыг даатгуулагч нь даатгагчтай урьдчилан бичгээр тохиролцсон байх; 3.2. Төлүүлж буй авлагууд нь даатгалын хугацаанд үүссэн байх ба даатгагчаас зээлийн шугам тогтоодог эсхүл тогтоосон худалдан авагчаар төлүүлсэн байх.						
	Даатгалын нэмэлт эрсдэл	-						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	1,0%-5,0%						